

Living the Lotus 3

Buddhism in Everyday Life

2026
VOL. 246

Тайланд



Камбож



Япон



Өмнөд Африк



Тайланд, Камбож салбарын залуучуудын энх тайвны мөргөл

Living the Lotus
Vol. 246 (2026.03)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1
Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бүгд нэгэн бүхэл

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Лянхуа сударт хүн ба дэлхийн талаар юу гэж сургадаг вэ?

Рисшо Косей Кай нийгэмлэгийн гишүүд бидний гол судар бол “Лянхуан Гурамсан Судар” (Хэмжээлшгүй Утгасын Судар, Гайхамшигт Ном Лянхуа Судар, Хотолд Сайн Бодисатвагийн Явдлыг Үзэхүй Судар) гэдгийг та бүхэн мэднэ. Тэр дундаа “Гайхамшигт Ном Лянхуа Судар”-т айлдсан хүн хийгээд дэлхий ертөнцийн талаарх сургаалыг бид чухалд үздэг.

Хүн ямар байх талаар энэрэн нигүүлсэх сэтгэлийг төрүүлж, эргэн тойрныхоо хүмүүсийг илүү аз жаргалтай болоосой, зовлон шаналал нь нимгэрээсэй хэмээн хүсэн залбирч, түүний төлөө үйл хийдэг хүн буюу бодисатва болохыг сургадаг. Хүн бүр боди сэтгэлтэй болохоо ухамсарлаж, бурханы мөн чанарынхаа дагуу үйл хийх аваас хүний ертөнц (сав ертөнц) тэр даруй амгалан гэрэлт орон болно гэж сургадаг нь Лянхуа судар дахь дэлхий ертөнцийн талаарх сургаал болно.

Мөн өнөөдөр бидний үзэж, сонсож байгаа дэлхийн асуудлаас авхуулаад эргэн тойрны асуудлыг хэн нэгэн, ямар нэг зүйл шийдэж өгнө гэсэн юм байхгүй. Бид өөрсдөө л хүний зам мөрөөс хазайхгүй, газраас хөөрөн гарч ирсэн бодисатва мэт замнахгүй л юм бол юу ч өөрчлөгдөхгүй гэж Лянхуа судар сургадаг гэж би ойлгодог.

Лянхуа судар “бидэн шиг эгэл жирийн энгийн ард түмэнд л чухамдаа нийгмийн амьдрал, дэлхий ертөнцийн асуудлыг шийдэх чадвар, үүрэг хариуцлага бий” гэдгийг дамжуулж, бодисатва болохоо ухамсарлахыг сургадаг. Тийм ч учраас “Хамаг амьтан бүхэн цорын ганц агуу оршихуйн ач ивээлээр амьдардаг”, “бүгд нэгэн бүхэл” гэдэг нь тус судрын гол ухагдахуун болдог.



Сансар огторгуй, дэлхий ертөнц бүгд нэгэн бүхэл

Үүсгэн байгуулагч “Би энэ холбоог байгуулсан нь гагцхүү хүн зоныг аврах юмсан гэсэн зорилгоос үүдэлтэй” гэж хэлсэн. Би сая Лянхуа судрыг дахин тайлбарласан нь тус нийгэмлэг үүсгэн байгуулагдсан зорилгыг эргэн санаж, “хүн зоныг аврах”-ын тулд “бүгд нэгэн бүхэл” гэсэн үзэл санааг зурх сэтгэлдээ шингээж авах хамгийн чухал учраас тэр юм.

“Бүгд нэгэн бүхэл” гэсэн ойлголт нь мэдээж хэрэг Лянхуа судрын Нэг хөлгөний сургаалаас үүдэлтэй. Ойлгомжтой хэлэх юм бол “сансар огторгуй, дэлхийн бөмбөрцөг, ертөнц бүгд нэгэн бүхэл” гэсэн үг.

Сансар огторгуй яг л нэг бүхэл нэг амьд биет мэт хувьсан өөрчлөгдөх явцад эх дэлхий үүсэж, тэнд хязгааргүй олон зүйл өөр хоорондоо зохицолдон биесээ тэтгэн оршиж ирсэн. Энэ бодит үнэн нь сансар огторгуй тэр чигээрээ нэгэн бүхэл агуу амь, хүмүүс бид ч гэсэн нэгэн бүхэл болохыг гэрчилнэ. Шашин талаас нь аваад үзсэн ч гэсэн дийлэнх шашин хамаг амьтан нэг бүхэл гэдгийг, энэрэн нигүүлсэх сэтгэлийг сургадаг. Мөн бурхан тэнгэрийг хүндлэн дээдэлж, эрхэмлэх тал дээр ч гэсэн нэгддэг. Тиймээс шашин төдийгүй хэн бүхэн жижиг сажиг зүйл дээр биесээ шүүмжлэн мэтгэлцэх бус нийтлэг үзэл санаагаа олж харж, “нэгэн ижил” болохоо ойлгох юм бол нэгнээ хүндлэх сэтгэл, уужуу ухаан төрж, амар амгалан, хүсэл мөрөөдлийг дэлгэрүүлэх ертөнц өргөжин тэлэх нь дамжиггүй. Гэвч бид хүн л юм болохоор энэ тийм амар зүйл биш.

Энэ талаар Үүсгэн байгуулагч “Хүн бүрт өөрийн гэсэн онцлог, зан ааш, байр суурь, шалтгаан бий. Түүнийг нь ойлгох юм бол аяндаа тэр хүнийг хүлээн зөвшөөрөх уужуу сэтгэл төрнө” гэж сургасан. Мөн Дэлхийн шашинтны энх тайвны 3-р чуулга (1979) дээр “Дэлхий ертөнц одоо нэг талыг барьсан үндсэрхэг үзлийг давж, бүс нутгийн хэмжээнд, цаашлаад бүр дэлхийн хэмжээнд бодож сэтгэдэг болох цаг ирэх нь ойлгомжтой” хэмээн өнөөгийн дэлхий ертөнцийн байдлыг урьдаас харсан юм шиг л анхааруулж байсан. Түүнээс хойш хагас зуун өнгөрсөн байхад тус нийгэмлэг одоо ч гэсэн “хүн зоныг аврах” гэсэн зорилгоо хангалттай биелүүлж чадаагүй байгаад сэтгэл минь эмзэглэж байгаа хэдий ч, бид бүгд “нэгэн бүхэл” дэлхийг бүтээн байгуулах үүрэг хариуцлагыг үүрч байгаа гэдгээ эргэн санаж, эргэцүүлэн бодох чухал гэж бодож байна.

«Косей» сэтгүүл, 3-р сарын дугаараас





“Бүгд нэгэн бүхэл” хэмээх эх үндэс рүүгээ буцах нь

Маэда Такаши

Та бүхэн сайн байцгаана уу?

Одоогоос 88 жилийн өмнө 1938 оны 3-р сарын 5-нд Рисшо Косей Кай холбоо үүсгэн байгуулагдсан. Үүсгэн байгуулагч “Би тус холбоог байгуулсан нь хүмүүсийг аврах гэсэн ганцхан зорилготой байсан” гэж хэлсэн. Тийнхүү тус холбоог байгуулах хөдөлгүүр нь “бүгд нэгэн бүхэл” гэсэн Лянхуа судрын Нэг хөлгөний үзэл санаа байсан юм.

Гэвч хүмүүс бид угтаа нэг бүхэл байсан зүйлийг юм л бол ангиллаж хуваах гээд байдаг. Сэтгэл ба бие, би ба бусад, хүн ба байгаль, сүсэг бишрэл ба энгийн амьдрал гэх мэт.

Лянхуа судар “энэ газар бол зам мөрийн газар” гэж сургадаг ба энэ нь сүсэг бишрэл өөрөө өдөр тутмын амьдрал болохыг илэрхийлнэ. Жишээлбэл сэтгэл өвдөхөөр бие махбодод өөрчлөлт гарч, түүнийг чимээгүйхэн сануулдаг шиг бид өөрийн хийгээд бурхан тэнгэрийн дуу хоолойг анзаарч сонсож чадах юм бол сургаал номын дагуу амьдрах байх. Бурхны сургаал ном сударт хадгалагдах бус амьдралын эргэлзээ төөрөгдөл дунд л амьд орших учиртай. Хүн өөрийн хүчээр амьдарч байгаа мэт харагдавч огтхон ч тийм биш, бусад хүмүүс, байгаль дэлхийн харилцан холбоон дунд олны тус дэмээр амьдардаг.

Байгууллагын ойн баяр тохиох энэ сард “бүгд нэгэн бүхэл” гэсэн үндэс суурь рүүгээ эргэн очиж, бурхны сургаалыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх нэг алхмыг хамтдаа хийцгээе. Өмнөх үеийнхэндээ талархаж, тэдний хүсэл зорилгыг уламжлан авч, өнөөдөр түүний төлөө замнах нь бидний үүрэг билээ.




*Гакурин сургуулийн гадаад оюутны 2-р курсийн сурагчидтай
хичээлийн дараа зургаа авхуулсан нь. 2 сарын 9*

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp